



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА:**

Нэг.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтыг хангах ажлын хүрээнд 1-2

1.2. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр: 2-3

Хоёр. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2.1.Хэлтсээс зохион байгуулсан ажил,үйлчилгээ..... 3-4

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл,нийгмийн баталгааг хангах

чиглэлээр 4-5

2.3 Тоон гарын үсэг 5-6

2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран
ажиллаж, хэрэгжүүлсэн ажил6-6

2.5 Хэлтсээс зохион байгуулсан шинэлэг ажил6-7

2.6 Монгол Улсын их хурлын 2024 оны сонгуулиар Улсын бүртгэлийн
байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийгдсэн
ажил.....

Гурав. СУРГАЛТ СУРТЧИЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

3.1. Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтууд:..... 7-10

3.1. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалтууд10-10

3.2. Хэлтсээс зохион байгуулсан сургалтууд:.....10-10

Дөрөв. ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ

ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР.....

10-12

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 12-12

Зургаа. ИРГЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:..... 12-13

Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР13-15

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР 15-15

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:16-17

Арав. ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:..... 17-19

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР: 19-22

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЧМЭЛ ТАЙЛАН

2024.11.20

Алтай хот

Нэг: ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1. Бодлого зорилтын хэрэгжилтийг хангах чиглэлээр:

Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий газар болон орон нутгийн удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, удирдамж чиглэл, тушаал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлага болгон хэрэгжилтийг өдөр тутмын ажил, үйлчилгээнд бүрэн хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээдэд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэл, иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг орон нутагт эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн Улсын бүртгэлийн үйлчилгээг **18** сум **88** багийн **58.400** гаруй иргэнд хүргэн ажиллаж байна.

1.2 Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Говь-Алтай аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГазрын даргын 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн Б/424 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, улсын бүртгэгч 25, архивч 1, нярав, бичиг хэргийн ажилтан 1, ахлах нягтлан бодогч 1, архивч, мэдээллийн технологийн ажилтан 1, гэрээт ажилтан 5 зэрэг нийт 38 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Хэлтсээс зохион байгуулсан ажил:

➤ Төрийн захиргааны албан хаагчидтай 2024 онд хэрэгжүүлэн ажиллах гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуульд заасан хугацаанд байгуулж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа .

➤ УБЕГ-ын даргын баталсан МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг 100 хувь хэрэгжүүлсэн.

➤ 2023 оны ХАСХОМ-ийг мэдүүлэх ёстой 28 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 01 сарын 21-нд багтаан сүлжээнд бүрэн шивүүлж, баталгааны маягтыг гаргуулан авч баталгаажуулан хадгалсан болно. Тайлант хугацаанд авилга, ашиг сонирхолын зөрчлийн асуудлаар иргэдээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээгүй. Хөрөнгө орлогоо мэдүүлэхээс татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтан байхгүй.

➤ Аймгийн Төрийн Аудитын газраас Хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын хяналт шалгалт хийж ямар нэгэн акт, зөвлөмж өгөөгүй бөгөөд “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан.

➤ 2024 оны 2 сард УБЕГ-аас санаачлан зохион байгуулсан малчдад туслах “БҮРТГЭЛИЙН ИЛЧ” хандивын аянд хэлтсийн албан хаагчид нэгдэж 360,000 төгрөг, Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан малчдад туслах аянд нэгдэж 500,000 төгрөгийг тус тус хандивласан.

➤ Хэлтсийн албан хаагчдад сар бүр онлайнаар хурал зохион байгуулж цаг үеийн байдал, болон тулгамдаж буй асуудал, Аймаг орон нутгийн удирдлага, УБЕГ-аас өгсөн үүрэг чиглэлийг тухай бүр танилцуулан ажилласан. Тайлант хугацаанд нийт 19 удаагийн онлайн хурал зохион байгуулсан байна. /Үүнд: Сонгуулийн төлөвлөгөөт ажлууд, тоон гарын үсэг, гадаад паспортын зураг авалт, үйлчилгээний хөлс, Шинэ хоршоо хөдөлгөөн, бусад цаг үеийн асуудлуудаар/

➤ Сумдад ажиллаж буй бүх улсын бүртгэгчид болон аймгийн төвийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтын байдалд хяналт тавьж 2024 оны 4 сарын 01-ны өдрөөс ERP программаар цаг бүртгэлийг явуулж ажлын цаг ашиглалтыг хянаж хэвшлээ.

➤ Тус хэлтсийн Улсын бүртгэгчээр ажиллаж байгаад Гаалийн Улсын байцаагчаар шилжин ажиллаж буй М.Аръяачойжилд 2024.03.20-ны өдөр хамт олны зүгээс хүндэтгэл үзүүлэв.

➤ Тус хэлтэс Аймгийн ардын дуу бүжгийн “Алтай чуулга”-тай хамтран 2024 оны 9 дүгээр сарын 22-ны билэгт сайн өдөр “Гэрлэлтийн гэрчилгээ” гардуулах ёслолын үйл ажиллагааг зохион байгуулав. Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц, Улсын бүртгэгч Д.Гүндэгмаа нар гэрлэж буй хосуудад “Гэрлэлтийн гэрчилгээ”-г гардуулан өгч баяр хүргэлээ.

➤ Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд тус хэлтэс 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 492 хоршоог хууль журмын дагуу улсын бүртгэлд бүртгэсэн байна.

➤ УБЕГ-ын Удирдлагын шуурхай хурлаас өгсөн 19 удаагийн үүрэг, даалгаврын биелэлтийг заасан цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж тайланг хүргүүлсэн.

➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Аймгийн Засаг даргын “108 сая мод тарих хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор намрын мод тарих ажлыг 2024.10.14-ны өдөр зохион байгуулав. Намрын мод тарилтын хүрээнд тус хэлтэс нь 100 ширхэг бургас, 100 ширхэг улиас модны суулгац суулгаж цэнэг усалгааг хийв.

➤ УБЕГ-аас Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 84 жилийн ой, “Улсын бүртгэлийн ажилтны өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулж буй аяны удирдамжуудын хүрээнд зохион байгуулсан ажлуудад идэвхтэй оролцож холбогдох тайлангуудыг заасан хугацаанд хүргүүлэн ажилласан.

2.2. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр:

➤ Хэлтсийн албан хаагчдын шагналын судалгааг шинэчлэн гаргаж, УБЕГ-аас 2024 оны 02 сарын 01-ны өдрийн 2/1460 тоотоор ирүүлсэн чиглэлийн дагуу шагнуулах албан хаагчдыг хамт олны хурлаар хэлэлцэн шагналын материалыг 2024 оны 02 сарын 17-ны өдрийн №09 тоотоор УБЕГ-т хүргүүлсэн.

➤ Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2024.05.11-ны өдөр 15 албан хаагч, 2024.10.03-ны өдөр 12 сумын улсын бүртгэгчийг Аймгийн ЭМГазартай хамтран хамрууллаа. Урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүнд 3 албан хаагч оношоо тодруулан зохих шатны эмнэлэгт хандан хэвтэж эмчлүүллээ.

➤ Идэвхтэй амралт, явган аялалын арга хэмжээг 2024.05 сард Хантайширын нуруунд зохион байгуулж 14 албан хаагч хамрагдсан.

➤ Албан хаагчдын ажиллах ая тухтай нөхцөл, иргэдийн үйлчилгээ авах таатай орчныг бүрдүүлэн хэлтсийн үйлчилгээний заалыг өргөтгөх ажлыг 2024.03 сард хийж үйлчилгээний танхимыг өргөтгөн тус танхимд үйл ажиллагаа явуулж байгаа улсын бүртгэгчдийн сургалтын өрөөг шинээр тохижуулж гадаад паспортын зураг авах өрөөг шинэчиллээ.

➤ Хамт олны чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Хэлтсийн байрны 2 давхарт дартс, теннисний өрөөг тус тус тохижуулан ашиглаж байна. Аймгийн БТСГазартай гэрээ байгуулан долоо хоног бүрийн 4 дэх өдөр волейбол, сагсан бөмбөгийн спортоор албан хаагчдыг хичээллүүлж байна. 2024 онд нийт албан хаагчдыг хамарсан спортын арга хэмжээг 3 удаа зохион байгуулав.

➤ Хэлтсийн архивыг өргөтгөж Эд хөрөнгө, хуулийн этгээдийн цаасан архивыг Хэлтсийн 2 давхарт нүүлгэн шилжүүлж стандартын дагуу тохижууллаа.

➤ Хэлтсийн дэргэдэх эцэг эхийн зөвлөл 4 удаа хуралдаж хэрэгжүүлэх үйл ажиллагааныхаа талаар ярилцан 2 арга хэмжээг хэлтсийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан. 2024 оны 09 дүгээр сарын 07-ны Бямба гарагт Хэлтсийн эцэг, эхийн зөвлөлөөс эцэг эхчүүдийн дунд волейболын тэмцээн зохион байгууллаа.

➤ Сонсголын бэрхшээлтэй 1 албан хаагчид сонсголын аппарат авахад нь зориулж хэлтсийн албан хаагчид 200,000 төгрөгний хандив цуглуулан дэмжлэг үзүүлсэн.

➤ 2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар Аймгийн ЗДТГазраас төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад орон нутгийн нэмэгдэлд 26,744,000.00 төгрөгийн нэмэлт санхүүжилт авч нийт 33 албан хаагчид орон нутгийн нэмэгдлийг сар бүр 10 хувиар тооцон олгож байна.

➤ Тус хэлтсээс албан хаагчдын ар гэрийнхэнтэй уулзаж, тэдний нийгмийн асуудал, санал хүсэлтийг сонсох, гэр бүлийн үнэ цэнэ, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор "ГЭР БҮЛИЙН УУЛЗАЛТ ЗӨВЛӨГӨӨН"- ийг 2024.10 сарын 02-ны өдөр зохион байгуулав. Зөвлөгөөний үеэр Хэлтсийн удирдлагаас ар гэрийнхний санал хүсэлтийг биечлэн сонсож, холбогдох зрим асуудлыг шийдвэрлэлээ.

➤ 2024 оны 10 дугаар сарын 01-ны өдөр "Олон улсын Ахмадын өдөр"-ийг тохиолдуулан тус хэлтэст ажиллаж байгаад гавъяаны амралтад гарсан 4 ахмад албан хаагчид хүндэтгэл үзүүлэн тус бүрд нь 165.000 төгрөгний дэмжлэг үзүүлж, гарын бэлэг гардууллаа.

➤ 2024.10.17-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан "ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ" аянд тус хэлтэс нэгдэж 370.000 төгрөгийн хандивыг хамт олны зүгээс хандивлалаа.

2.3 Тоон гарын үсэг:

➤ Тоон гарын үсэг олгох ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд хамрагдалт багатай байгаа Есөнбулаг сумын засаг дарга А.Алтанхуяг, багийн засаг дарга нартай 2024.03.02-ны өдөр Хэлтсийн дарга, Иргэний улсын ахлах бүртгэгч, Мэдээлэл технологийн ажилтан нар ажил хэргийн уулзалт зохион байгуулж хамтран ажиллах төлөвлөгөө 8 заалт бүхий гарган тоон гарын үсэг олголтын ажлыг эрчимжүүлэн ажиллалаа.

➤ Тоон гарын үсгийн ач холбогдол бүхий мэдээ мэдээллийг аймгийн төв талбайн дэлгэцээр байнга сурталчилж нийт 7600 гаруй иргэнд мэдээллийг хүргэсэн байна. Мөн тоон гарын үсэгтэй холбоотой ярилцлагыг фэйсбүүкийн лайв сурвалжлагаар 3 удаа хийж иргэдэд мэдээлэл өглөө.

➤ 2024 оны 1 сарын 31-ны өдрөөс тус хэлтсийн байранд байрлах Киоск машиныг байнгын 24 цагийн ажиллагаатай болгож байгаа иргэдэд цаг хугацаа харгалзахгүйгээр тоон гарын үсэг олгон ажиллаж байна.

- Тоон гарын үсэг олгох ажлын хүрээнд 3 удаа арга хэмжээ зохион байгуулж, 2024 оны 11 дүгээр сарын 18-ны байдлаар нийт 30,782 иргэнд тоон гарын үсэг олгож 82,0 %-тай байна

2.4. Аймаг, орон нутгийн удирдлага болон бусад байгууллагуудтай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн ажил:

- Говь-Алтай аймгийн Биеийн тамир, спортын газраас зохион байгуулж буй "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд "Хүн амын бие бялдар чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил"-д Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчид 2024.04.05-ны өдөр хамрагдлаа.

- Хүний эрхийг хангах ажлын хүрээнд тус хэлтэс Аймгийн ШШГГ, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай тус тус хамтран бичиг баримтаа үрэгдүүлсэн 16 иргэнд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж бичиг баримтжууллаа.

- Улсын бүртгэлийн **"Нээлттэй өдөр"** арга хэмжээг дараахь байгууллагуудтай хамтран 5 удаа зохион байгуулсан.

Үүнд:

- 2024.02.05-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран
- 2024.05.01-ны өдөр Аймгийн Засаг даргын тамгын газар, Хуулийн хүрээний тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран "ПРО БОНО" өдөрлөг
- 2024.05.17-ны өдөр Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 589 тоот "Байгууллага сурталчлах аян"-ны хүрээнд Нээлттэй өдөрлөг
- 2024.09.20-ны өдөр Аймгийн Засаг Даргын Тамгын Газар, ХХҮГ, ГБХЗХГазруудтай хамтран **"ХҮРЧ ҮЙЛЧИЛНЭ"** аяны хүрээнд "Нээлттэй өдөрлөг"
- 2024.10.02-ны өдөр Аймгийн Нийгмийн Даатгалын газар, ХХҮГазартай хамтран Шинэ-Алтай захын гадна талбайд **"АХМАДАА ХАЙРЛАЯ, ХҮНДЭТГЭЭ"** сэдэвт "Нээлттэй өдөрлөг"-ийг тус тус зохион байгууллаа. Дээрхи зохион байгуулсан 5 "Нээлттэй өдөрлөг"-ийн үеэр иргэдэд Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний талаар мэдээллийг өгч нийт 72 иргэн, 28 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэж 643 иргэнд тоон гарын үсэг олгож 9 ахмад настанд гарын бэлэг олголоо.

- Тус Хэлтсийн 19 албан хаагч Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ын хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр явуулсан "Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль"-д идэвхтэй хамрагдлаа.

- 2024.09.14-ны өдөр "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээний хүрээнд аймгийн "Жангар" нийтийн номын сангаас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцож, "Шилдэг уншигч байгууллага"-аар шалгарлаа.

- Тус хэлтсээс байгууллагын аюулгүй байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дагуу эрсдэлийг үнэлж, болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах 59 дүгээр ангитай хамтран 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр гал унтраах дадлага сургуулилт хийв. Энэ үеэр Аймгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын байцаагч, хошууч С. Энхбаяр "Галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх чиглэл" сэдвээр сургалт зохион байгуулж, тусгай томилгоот бүлгийн алба хаагчдыг томилгоожуулан үүрэг чиглэл өгсөн.

2.5 Хэлтсээс зохион байгуулсан шинэлэг ажил:

- Тус хэлтэс нь иргэдэд төрийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, шуурхай хүргэх зорилгоор 2024 оны 1 дүгээр сарын 31-ны өдрөөс “24/7 ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ”-г үзүүлж, 2024.10.31-ны өдрийн байдлаар КИОСК машинаас: Лавлагаа-4119, Тоон гарын үсэг-5210 үйлчилгээг авсан байна.
- Тус Хэлтсээс 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Аймгийн Цагдаагийн газартай хамтран хүүхэд болон эцэг эхчүүдэд цахим хэрэглээний хор уршгийг таниулах хүүхдийн хүмүүжил төлөвшил болон тэдгээрийг гэмт хэрэг зөрчил, цахим орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зорилгоор 2 цагийн сургалт зохион байгуулж “ЦАХИМ ХАЛДЛАГААС ХҮҮХДЭЭ ХАМГААЛЪЯ” сэдэвт уриалгыг дэвшүүллээ.

2.6 Монгол Улсын их хурлын 2024 оны сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт:

- МУИХ-ын 2024 оны ээлжит сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд УБЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан орон нутагт хийж хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө боловсруулж ажлын гүйцэтгэлийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан.
- Тус аймгийн 18 сумын хэсэг байгуулсан тухай ИТХ-ын тогтоолыг хүлээн авч мэдээллийн санд шивэн баталгаажуулж эх хувийг УБЕГ-т хүргүүлж, сонгуулийн насны эрх бүхий сонгогчдын нэрийн жагсаалтанд бүртгэгдсэн хэсэг оноогдоогүй болон шинээр үүсэн хэсэгт хуваагдсан иргэнд хэсэг оноох ажлыг, хуулийн хугацаанд оноож, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг хуулийн хугацаанд хааж мэдээ тайланг ИУБГ-т хүргүүлсэн.
- Монгол Улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулиар тус хэлтсийн албан хаагчдын сумдыг хариуцан ажиллах хуваарийг баталж хэрэгжилтийг хангуулсан.
- Монгол Улсын их хурлын 2024 оны ээлжит сонгууль болохтой холбогдуулан иргэдийн шилжилт хөдөлгөөний бүртгэл болон УБЕГ-ын цахим сайтад 4 сарын 01-ны өдрөөс байршуулсан сонгогчийн нэрийн жагсаалтын талаар Алтайн мэдээ, Миний нутаг тв, Алтай радиогоор 3 удаагийн мэдээллийг иргэдэд хүргэж, сумдын пейж хуудас, сайтад энэ талаар шейрлэж тараалаа.
- 2024 оны 04 сарын 29-ны өдрийг хүртэлх тус аймгийн иргэдийн шилжилт хөдөлгөөний талаархи болон шилжилт хөдөлгөөнийг зогсоосон тухай мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулан иргэдэд 2024.05.03-ны өдөр лайв хийж хүргэлээ.
- Сонгогчийн нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд хэвлэж, Сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлсэн.
- Монгол Улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах төрийн албан хаагчдын судалгааг гарган Аймгийн Тагнуулын хэлтэст хандан аюулгүй байдлын шалгалтанд хамруулж шаардлага хангасан 90 албан хаагчтай хөлсөөр ажиллах гэрээг 2024.05.31-ны өдөр байгууллаа.
- Монгол Улсын их хурлын 2024 оны ээлжит сонгуулийн өдөр Улсын бүртгэлийн байгууллагын хүлээсэн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэн ажилласан. Алдаа, зөрчил гараагүй.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны ээлжит сонгуулийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан байдал:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн 2024 оны ээлжит сонгуулийн тухай хуулийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 25 заалт

бүхий дэд төлөвлөгөөг Хэлтсийн даргын тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

- Сонгуультай холбоотойгоор иргэдэд тус шилжилт хөдөлгөөний талаархи болон шилжилт хөдөлгөөнийг зогсоох тухай мэдээллийг Аймгийн АлтайТВ-р дамжуулан мэдээлэлийг хүргэсэн.
- Сонгогчийн нэрийн жагсаалтыг хуулийн хугацаанд хэвлэж, Сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлсэн.
- 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулиар Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар ажиллах төрийн албан хаагчдын судалгааг гарган Аймгийн Тагнуулын хэлтэст хандан аюулгүй байдлын шалгалтанд хамруулж шаардлага хангасан 88 албан хаагчтай хөлсөөр ажиллах гэрээг 2024.09.15-ны өдөр байгууллаа.
- 10 сумын 35 хэсгийн хороонд сүлжээний тархалтын судалгааг амжилттай хийснээр Сонгуулийн өдөр сүлжээний талаар ямар нэгэн доголдол гараагүй.
- 2024 оны орон нутгийн ээлжит сонгуулийн өдөр алдаа, зөрчил гараагүй.

Гурав: СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Тус хэлтсийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, эрүүл мэндийг хамгаалах зэрэг ажлуудын хүрээнд 2024 онд явагдах сургалт, сурталчилгааны төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний дагуу ажлуудыг зохион явууллаа.

3.1. Улсын бүртгэлийн ерөнхий газраас зохион байгуулсан сургалт

Танхимаар зохион байгуулсан сургалт:

- 2024 оны 04 сарын 4,5-ны өдрүүдэд сумдад Эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах төслийн нээлтийн семинар-хэлэлцүүлэг сургалтанд хэлтсийн дарга хамрагдсан.
- УБЕГ-аас 2024 оны 08 сарын 14,15-ны өдрүүдэд “Эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах” төслийн хүрээнд Дорнод аймагт зохион байгуулсан сумдын улсын бүртгэгчдийг чадавхжуулах сургалтанд 24 албан хаагч хамрагдлаа.
- УБЕГ, Койка олон улсын байгууллага хамтран албан хаагчдыг чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд 2024.09 сард Солонгос улсад зохион байгуулсан 10 хоногийн сургалтанд тус Хэлтсийн хяналтын улсын байцаагч Д.Оюунчимэг хамрагдлаа.

Онлайнээр зохион байгуулсан сургалт:

- 2024 оны 04 сарын 01-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн газар, Улсын бүртгэлийн нэгдсэн архивын газартай хамтран зохион байгуулсан “Архивын лавлагаа олгох” талаархи онлайн сургалтанд хэлтсийн 18 албан хаагч
- 2024 оны 05 дугаар сарын 01, 07-ны өдрүүдэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас зохион байгуулсан онлайн сургалтанд хэлтсийн улсын бүртгэгчид
- 2024 оны 04 сарын 26-ны өдөр УБЕГ-аас зохион байгуулсан Хуулийн этгээд болон Эд хөрөнгийн улсын ахлах бүртгэгч нарын сургалтанд Улсын ахлах бүртгэгч болон хуулийн этгээдийн улсын бүртгэгч
- 2024 оны 8,9,10,11 саруудад ХЭУБГ-аас зохион байгуулсан 6 удаагийн сургалтанд Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх олгогдсон улсын бүртгэгчид тус тус хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалт:

- 2024 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн “Дижитал шилжилт, Виртуал орчинд ажиллах” сэдэвт сургалтанд хэлтсийн 19 албан хаагч
- 2024 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн “Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт” сэдэвт онлайн сургалтанд 21 алба хаагч
- 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Төрийн албан хаагчийн үндэсний бичлэгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II зохион байгуулах” сэдэвт онлайн сургалтанд 6 албан хаагч
- 2024 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн “Монгол төрийн зүтгэлтний хэв шинж/ХХ зууны эхэн хагас/” сэдэвт онлайн сургалтанд 20 албан хаагч
- 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Төрийн албан хаагчийн үндэсний бичлэгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-ны явц онлайн сургалтанд 18 албан хаагч
- 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ыг хэрэгжүүлэх тухай сэдэвт онлайн сургалтанд 29 албан хаагч
- 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн “Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа” сэдэвт онлайн сургалтанд 14 албан хаагч
- 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн “Төрийн албаны шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн”, “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа” сэдэвт онлайн сургалтанд 31 албан хаагч
- 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн “Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж үр дүн” сэдэвт онлайн сургалтанд 5 албан хаагч
- 2024 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн “Төрийн албан хаагчийн суралцах идэвх, Койка-гийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаархи мэдээлэл, зөвлөмж” сэдэвт онлайн сургалтанд 18 албан хаагч
- 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль(шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт онлайн сургалтанд 14 албан хаагч
- 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт онлайн сургалтанд 3 албан хаагч
- 2024 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн “Төрийн албан хаагчдын сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” сэдэвт онлайн сургалтанд 11 албан хаагч
- 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн “Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд” сэдэвт онлайн сургалтанд 12 албан хаагч
- 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн “Төрийн албан хаагчийн ёс зүйн манлайлалыг дэмжих, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлэх” сэдэвт онлайн сургалтанд 22 албан хаагч тус тус хамрагдаж мэдлэг, мэдээлэлийг авлаа.

3.2. Аймаг орон нутгаас зохион байгуулсан сургалт:

- 2023 оны 10 дугаар сарын 17,18-ны өдрүүдэд Аймгийн Засаг Даргын Тамгын газраас Удирдлагын академийн эрдэмтэн багш Доктор, дэд профессор Т.Алтанцэцэг, Доктор С.Жаргалсайхан нартай хамтран зохион байгуулсан “Төрийн байгууллага дахь харилцаа маркетинг” сэдэвт сургалтанд Хэлтсийн 18 албан хаагч хамрагдлаа.
- Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Тандалт судалгааны багийн судлаач, ахлах референт Т.Оюунаар ахлуулсан ажлын хэсгээс тус аймагт 2024.11.06-ны өдөр зохион байгуулсан Төрийн албан хаагчийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц системийг хөгжүүлж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг боловсронгуй болгох зорилтын хүрээнд шинээр болон шинэчлэн боловсруулсан журмын төслүүдийг танилцуулах сургалтанд Хэлтсийн дарга Г.Чүлтэмжамц хамрагдлаа.

3.3. Хэлтсээс зохион байгуулсан сургалт:

- 2024 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Улсын бүртгэлийн хэлтсээс “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудлаар” онлайн сургалт зохион байгуулж төрийн захиргааны 29 албан хаагч
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулсан цахим сургалтанд 20 албан хаагч
 - 2024 оны 05 сарын 30,31-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Б.Алтансүхтэй хамтран сумдаас хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх эрх олгогдсон Алтай, Баян-Уул, Бигэр, Дэлгэр, Тонхил, Халиун, Цогт, Цээл, Хөхморьт, Чандмань, Эрдэнэ сумдын улсын бүртгэгчийг Аймгийн төвд ирүүлж Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлууд, программын талаархи сургалтыг зохион байгууллаа.
 - Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг суманд үзүүлэх эрх олгогдсон Улсын бүртгэгч Д.Алтанцэцэг, Г.Баасанжаргал, Б.Одонтуяа, Н.Золжаргал, Б.Хүрлээ, Ш.Соёлдэлгэр нарыг 2024.05.20-ны өдрөөс 05.31-ны өдрийн хооронд Аймгийн төвд ирүүлж Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяагийн удирдлаганд дадлага хийлгэлээ.
 - 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Хамт олны дунд эерэг хандлага , нөхөрсөг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Харилцан хүндлэл ба байгууллагын соёл” сэдвээр сургалтыг зохион байгууллаа.Тус сургалтыг аймгийн Насан туршийн суралцахуйн багш Г.Баярсайхан, А.Эрдэнэсүрэн нар удирдан явуулсан бөгөөд нийт 25 албан хаагч хамрагдлаа.

Дөрөв: ХЭЛТСИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Цахим хаяг: <https://govi-altai.burtgel.gov.mn/>

Фэйсбүүк хаяг: /Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс/

Фэйсбүүк хаяг: /[GAA-n UBHeltes](#)/ /байгууллагын албан хаагчид зөвхөн орох, дотоод албан бичиг, мэдээ мэдээлэл солилцох/:

Вэб хуудасны хөгжүүлэлт:

- Албан хаагчдын мэдээлэл, газар орны мэдээллүүдийн өөрчлөлтийг тухай бүр нь шинэчилсэн.
- [Shilen.gov.mn](#) /ПЛАТПОРМЫГ/ хэлтсийн вэб хуудсанд холбож хэрэгцээт мэдээ тайланг тухай бүр оруулан ажиллаж байна.
- Вэб-д оруулах бүх цэсэнд тохирсон мэдээллүүдийг тухай бүр байршуулж ажилласан.
- Вэб-д оруулсан мэдээллийн линкийг байгууллагын фэйсбүүк хаягаар дамжуулан байнга сурталчилан ажилласан.

Вэб хуудасны ангилал	Оруулсан мэдээний тоо
Санхүүгийн ил тод байдал	10
Хурал, сургалт семинар, хэлэлцүүлгийн зар	3
Жил улирлын тайлан	1
Нээлттэй ажлын байрны зар	0
Өргөдөл гомдол шийдвэрлэсэн байдал	31
Сар бүрийн тоон мэдээлэл	10

Түгээмэл асуулт хариулт	14
Цаг үеийн мэдээ	18
Видео мэдээ	9
Топ мэдээ	6
Нийт байршуулсан мэдээ	102

Сурталчилгааны чиглэлээр:

➤ Байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг хэлтсийн цахим хуудас, фэйсбүүк хаяг болон үйлчилгээний зааланд байршуулж иргэдэд мэдээлэл хүргэн ажиллав.

➤ Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, МУИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуультай холбоотой иргэний шилжилт хөдөлгөөний талаар “live сурвалжлага”-г 4 удаа хийж иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэсэн байна.

➤ Бүртгэлийн үйлчилгээний үнэ тариф, бүрдүүлэх нотлох баримт бичиг, үйлчилгээний хөлс тушаах дансны мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх улсын бүртгэгчийн мэдээлэл, үйлчилгээ авах цэг, хаяг байршлыг агуулсан самбарыг үйлчилгээний танхимд байршууллаа.

Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” А/02 тоот тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл хүлээн авах, хадгалах, түүний аюулгүй байдлыг хангах журам”-ийн дагуу үйл ажиллагааны аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.

➤ Албан хаагчдын компьютерийн плаш оролтуудыг бүрэн хааж, аюулгүй байдлын санамжийг компьютер болгон дээр наасан.

➤ Албан хаагчдын ашиглаж байгаа компьютер болон програмуудын нууц үгийг 14 хоногоос 1 сарын дотор солиулж, бүртгэл хөтлөн ажиллалаа.

➤ Хэлтсийн архив, сүлжээ сервер болон үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлчилгээний заал, коридор, байгууллагын гадна болон дотор хаалга зэрэгт 4 камер байршуулан хяналтыг сайжрууллаа.

➤ Үйл ажиллагаанд ашиглаж байгаа компьютер, процессорыг эрсдэлээс урьдчилан сэргийлж “УБЕГ” лацаар лацдаж бүртгэл хөтөлсөн.

➤ Хэлтсийн үйл ажиллагаанд ашиглагддаг 9 компьютерийг BITDEFENDER вирусны жилийн лицензтэй програмаар хамгаалсан.

➤ Тус хэлтсийн үйлчилгээний заалны өргөтгөлтэй холбоотой дотоод сүлжээний дахин төлөвлөлтийн ажил хийгдэж, үүнтэй холбоотой дотоод сүлжээний аюулгүй байдлыг хангах хүрээнд ашиглах шаардлагагүй сүлжээний кабель, шинээр ил гарсан кабелийн утсуудыг цэгцлэн албан хаагчдын ажиллах нөхцлийг бүрдүүлж хэвийн ажиллаж байна.

Сервер, компьютер тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ:

➤ Хэлтсийн серверийн рөүтерийг МТГ-аас Sophos router-ээр шинэчилсэн бөгөөд тохиргоог заасан хугацаанд нь хийлгүүлэн ашиглаж байна.

➤ Хэлтсийн төв серверийг байгууллагын өрөө тасалгааны дахин төлөвлөлттэй холбоотой нүүлгэн шилжүүлж, аймгийн төвийн дотоод сүлжээ дамжуулагч Media Convertor шатсаныг хэвийн ажиллагаанд орууллаа. Бугат, Бигэр, Хөхморьт, Шарга, Баян-Уул, Алтай, Цээл, Дарив, Тонхил сумдын сүлжээний доголдлыг УБЕГ-ын МТГазрын инженертэй холбогдон тохируулж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

Хийгдсэн ажлууд:

“Шинэ хоршоо” хөдөлгөөний хүрээнд Говь-Алтай аймагт ажиллаж буй ажлын хэсгийн ажилтнуудын ашиглаж буй компьютер, тоног төхөөрөмжийн

хэвийн ажиллагааг хангаж компьютер, тоног төхөөрөмжийн тохиргоо, засвар үйлчилгээг тухай бүр хийж ажилласан.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн болон АНСДИТХ-ын сонгуулийн ажлын бэлтгэл ажлын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу дараах ажлуудыг хийлээ.Үүнд:

- 3G, 4G сүлжээний сүлжээний судалгаа
- Тухайн санал өгөх байрны уртраг, өргөрөг тогтоох /байршил/
- Санал өгөх байранд 4G модем турших ажлын хүрээнд сүлжээгүй болон 2G, 3G сүлжээтэй газруудад туршилт хийж судалгааг илгээх.
- Сонгуульд ашиглах тоног, төхөөрөмжийг Тагнуул болон Цагдаагийн хамгаалалтанд татан авчрах
- Итгэмжлэгдсэн ажилтны сургалт зохион байгуулах
- Туршилтын сонгууль
- 2024.06.28-ны сонгуулийн өдөр ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах
- Итгэмжлэгдсэн ажилтнуудаас тоног төхөөрөмж хүлээн авч лацдах
- Сонгуульд ашигласан тоног, төхөөрөмжийг хуваарийн дагуу Тагнуулын ажилтан болон Цагдаагийн ажилтны хамгаалалтанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж, хүлээлгэн өгөх.
- Сонгуулиар ашиглагдсан баримт бичгүүдийг цэгцэлж архивын баримт үүсгэсэн гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аймаг, Нийслэл, Сум, Дүүргийн, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн ажлын бэлтгэл ажил хангах үүднээс Улсын бүртгэлийн ерөнхий газрын Мэдээлэл технологийн газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу дараах ажлууд хийгдсэн:

- Өөрчлөгдсөн хэсгийн хорооны санал авах байрны уртраг, өргөрөг авах /байршил/ тогтоож мөн сүлжээ унах магадлалтай хэсгийн хорооны сүлжээнд тандалд хийн судалгааг илгээх
- Сонгуульд ашиглах тоног, төхөөрөмжийг Тагнуул болон Цагдаагийн хамгаалалтанд татан авчрах
- Итгэмжлэгдсэн ажилтны сургалт зохион байгуулах
- Туршилтын сонгууль
- 2024.10.11-ны сонгуулийн өдөр ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах
- 2024.10.13-нд Алтай, Баян-Уул, Бугат, Цээл, Чандмань, Шарга сумдын дахин сонгуулийн үйл ажиллагааны компьютер, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах
- Итгэмжлэгдсэн ажилтнуудаас тоног төхөөрөмж хүлээн авч лацдах
- Сонгуульд ашигласан тоног, төхөөрөмжийг хуваарийн дагуу Тагнуулын ажилтан болон Цагдаагийн ажилтны хамгаалалтанд Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлж хүлээлгэн өгөх
- Сонгуулиар ашиглагдсан баримт бичгүүдийг цэгцэлж архивын баримт үүсгэн хадгалах гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Тав. БИЧИГ ХЭРГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- Тайлант хугацаанд тус хэлтсээс нийт **433** албан тоотыг явуулснаас Хууль хяналтын байгууллагад 80, Аймгийн ЗДТГ, ИТХ-д 87, УБЕГ-т 208, бусад албан байгууллага аймаг руу 58 албан бичгийг тус тус хүргүүлсэн байна.
- **691** албан бичиг ирсэн. Үүнд: Хууль хяналтын байгууллагаас 175, Аймгийн ЗДТГ, ИТХ-аас-78, УБЕГ-аас 340, бусад байгууллагаас 118 бичиг ирсэн байна.
- Тайлант хугацаанд хэлтэст нийт **400** хариутай бичиг ирсэн. Үүнд: Хууль, хяналтын байгууллагаас 113, аймгийн ЗДТГ, ИТХ-аас 53, УБЕГ-аас 162, бусад байгууллагаас 72 албан бичиг ирсэнийг холбогдох албан хаагчид даргын цохолтоор хүргүүлж 100 хувь шийдвэрлэсэн.
- Хэлтэст нийт **61** өргөдөл ирснээс 58 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж 3 өргөдөл шийдвэрлэх шатандаа байгаа талаар батлагдсан маягт, хүснэгтийн дагуу нэгтгэж тайлан мэдээг УБЕГ болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлэн ажиллалаа.

Зургаа. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2024 онд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл-711, гэрлэлт-161, эцэг тогтоолт-31, овог нэр нэр өөрчлөлт-34, нас баралт-271, гэрлэлт цуцлалт-21, үрчлэлт-11, иргэний үнэмлэх шинээр болон дахин 2088, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлээр аймаг хотоос ирсэн 458, аймаг доторхи шилжилт хөдөлгөөний бүртгэлээр 947 бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүлсэн байна. Эдгээр бүртгэл тус бүрийн хуульд заасан нотлох баримт болох 8060 хуудас цаасан баримтыг цахимжууллаа.
- Үндэсний энгийн гадаад паспорт авах **2417** иргэний хүсэлтийг хүлээн авч баталгаажуулж, гадаад паспортыг иргэдэд олгон, 1900 хуудас архивын цаасан баримтыг цахимжуулсан байна. 2024 онд улсын бүртгэгчдээс тоон гарын авах хүсэлт гаргасан **4140** иргэнд тоон гарын үсэг олгосон.
- Архивын чиглэлээр иргэдэд болон албан хэрэгцээнд зориулж нийт-3176 лавлагаа олгосноос иргэдэд-1928, хууль хяналтын байгууллагын албан тоотой-900, албан хэрэгцээнд-348 лавлагаа тус тус гаргаж, иргэний баримтын архивын хувийн хэргийн санд ИУБ-11-ИУБ-18 маягт 3467 төрөлжүүлэн байршуулж, бусад аймаг хотруу шилжин явсан 12 хувийн хэргийг ялган шилжүүлсэн байна. Аймаг хотоос шилжин ирсэн-43 иргэний хувийн хэргийг галиглан архивт байршуулсан байна.
- Сарын мэдээ болон цаг үеийн тайлан мэдээг тухай бүрд нь нэгтгэн гаргаж холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлжээ.
- МУИХ болон АНСДИТХ-ын сонгуулийн хуульд заасан чиг үүргийн дагуу УБЕГ-ын сонгуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хуулийн хугацаанд алдаа зөрчилгүй хийж тухай бүрд нь илтгэх хуудсаар тайлагнасан.

Долоо. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2024 онд иргэд хуулийн этгээдийн Эд хөрөнгө өмчлөх эрх болон түүнтэй холбоотой бусад эрхийн **4401** мэдүүлэг хүсэлтийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэв. Үүнд газраас бусад үл хөдлөх хөрөнгө анх удаа өмчлөх эрхийн **94**, шинээр баригдсан орон сууц өмчлөх эрхийн **126**, төрөөс худалдаж авсан үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн **1**, төрөөс хувьчилсан газар өмчлөх эрхийн **76**, худалдах худалдан авах гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх **328**, бэлэглэх гэрээгээр өмчлөгч өөрчлөгдөх **138**, өв залгамжлалаар өмчлөгч өөрчлөгдөх **59**, хамтран

өмчлөгч өөрчлөгдөх **28**, өмчлөгчийн хүсэлтээр болон гэрээгээр шинэ бүртгэл үүсэх **127**, бусад хэлбэрээр өмчлөх эрх шилжих **4**, барьцаат зээлийн гэрээний **1632**, барьцаат зээлийн гэрээ дуусгавар болгох **1468**, лавлагаа хуулбар олгох **74**, бүртгэлд өөрчлөлт оруулах **140**, бусад гэрээний **2**, гээгдүүлсэн болон гэмтээсэн гэрчилгээ дахин олгох **22**, бүртгэл хаах **82** бүртгэлийг тус тус хийж гүйцэтгэлээ.

➤ Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар иргэн, хуулийн этгээдээс **56.388.264** төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар **3.949.314** төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны татварын орлого **421.205.790** төгрөг тус бүрийг улсынболон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр хийгдсэн бусад ажил:

➤ Бүртгэлийн тоон мэдээ, судалгааг хугацаанд нь ЭХЭУБГазар болон ХЭУБГазарт, санхүүтэй холбогдох тайлангуудыг хугацаанд нь нэгтгэн тайлагналаа.

➤ 2024 онд эд хөрөнгийн цахим мэдээллийн санд буруу боловсруулсан, алдаатай цахимжуулсан, зурган мэдээлэл нээгдэхгүй байсан 126 бүртгэлийн 166 алдаатай мэдээлэл засвар өөрчлөлт оруулж залруулж тайланг сар бүр файл хэлбэрээр ЭХЭУБГазарт хүргүүлсэн.

➤ Цахим мэдээллийн санд нэгж талбарын дугаарыг цахимжуулаагүй гэзрйн мэдээллийг нягтлан шалгаж хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн дагуу 234 өмчлөлийн газрын мэдээлэлд нэгж талбарын дугаар нөхөж оруулж заслаа.

➤ ЭХЭУБГазраас ирүүлсэн 5/10482 тоот албан бичгийн дагуу Эд хөрөнгийн мэдээллийн санд Г дугаар олгогдсон бөгөөд Газрын дугаар олгох системээс Э дугаар олгогдсон иргэн хуулийн этгээдийн эзэмших ашиглах газрын дугаар давхардсан бүртгэлийг нягтлан шалгаж хяналтын улсын байцаагчийн дүгнэлт үндэслэж 90 хувийн хэрэг бүртгэл хаах ажлыг хийсэн.

➤ ЭХЭУБГазрын 5/2717 тоот албан бичгээр ирүүлсэн барьцааны гэрээ дуусгавар болгох бүртгэлийг онлайнаар хүлээн авах, 5/4803 тоот албан бичгээр ирүүлсэн ЭХЭУБТХуулийн нэмэлт өөрчлөлтөөр оруулсан улсын бүртгэлд тусгах эд хөрөнгийн үнэтэй холбогдох чиглэл, 5/10252 тоот албан бичгээр ирүүлсэн барьцаалбарын маягт шинэчлэгдсэнтэй холбогдох үүрэг чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд банкууд, ББСБ, нотариат, ГХБХБГазарт албан бичиг хүргүүлж, мэдээлэл солилцож хамтран ажиллалаа.

УБЕГ-ын даргын 2024.05.15-ны Б/297, Б/298 тоот “Сумдын эрх зүйч мэргэжилтэй улсын бүртгэгч нарт эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрх олгох тухай” тушаалын хэрэгжилтийн хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

➤ 2024.05.20-2024.06.07-ний хооронд эрх олгогдсон 11 сумын улсын бүртгэгч нарыг тусгай хуваарийн дагуу аймгийн төвд компьютер тоног төхөөрөмжийн хамт ирүүлж эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр хууль эрх зүйн болон программын сургалтанд хамруулж мэргэжил арга зүйгээр хангалаа.

➤ 2024.05.30,31-ний өдрүүдэд МУЗГ-аас хэрэгжүүлсэн “Шинэ хоршоо хөдөлгөөн” хөтөлбөрийн хүрээнд 11 сумын улсын бүртгэгчийг хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх, мэдээлэл лавлагаа өгөх, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг ханган ажиллах талаар хууль эрх зүйн болон ажлын байрны сургалтанд хамрууллаа. Сургалтыг Улсын ахлах бүртгэгч Б.Энхзаяа, Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэгч Б.Алтансүх нарын удирдлаган дор хийсэн. Сургалтын үр дүнд бүртгэлийн үйлчилгээг сумаас үзүүлэх нөхцөл боломж хангагдаж эхэлсэн.

➤ Эрх олгогдсон сумын бүртгэгч нар эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр нийт 405 бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч 100% шийдвэрлэсэн байна.

- Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 11 суманд нийт 278 бүртгэл хийгдэж, 204 хуулийн этгээдийн оноосон нэр олгосон байна.

Найм. ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

- 2024 онд хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 4860 иргэнд зөвлөгөө, мэдээлэлийг өгч, **2001** мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд нь 100% шийдвэрлэв. Үүнд:

Шинээр хуулийн этгээд байгуулах **566**, Хязгаарлагдмал хариуцлагатай компани-**58**, Төрийн бус байгууллага-**14**, Төрийн байгууллага, албан газар-**2**, нөхөрлөл-**2**, хоршоо-**492**, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулсан **356**, лавлагаа хуулбар олголт **119**, хуулийн этгээдийн татан буугдах бүртгэл **4**, хуулийн этгээдийн дахин гэрчилгээ олголт **28**, хуулийн этгээдийн оноосон нэр баталгаажуулах бүртгэл **360** тус тус бүртгэж баталгаажуулсан байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3-т заасны дагуу Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулах **4** хуулийн этгээдийн салбарыг шинээр болон нэмэлт өөрчлөлтийг бүртгэсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018оны А/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу хуулийн этгээдийн тамга, тэмдэгийн хяналтын хуудас 598 олгож хуулийн этгээдийн **32** тамга тэмдэгийг хураан авч хүчингүй болгосон.

- Цахим систем болох E-Business системээр хуулийн этгээдийн оноосон нэр авах **1677** хүсэлт ирснээс давхардал үүсээгүй боломжтой **85** хуулийн этгээдийн нэрийг баталгаажуулсан

- 2024 онд Монгол Улсын Засгийн Газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 166 тогтоолын дагуу “Шинэ Хоршоо Хөдөлгөөн” өрнүүлэх тухай ажлын хүрээнд 492 хоршоог улсын бүртгэлд бүртгэж баталгаажуулан гэрчилгээг олгосон байна.

- Хуулийн этгээдийн бүртгэлийг тус аймгийн **11** сумаас үзүүлж байгаа бөгөөд эдгээр сумын бүртгэгчид нийт **278** бүртгэл хийж, 204 хуулийн этгээдийн оноосон нэр олгосон байна.

- Бүртгэлийн үйлчилгээний хураамжаар **11.680.000** төгрөг, улсын тэмдэгтийн хураамжаар **25.294.000** төгрөг тус бүрийг улсын болон орон нутгийн төсөвт тушаалгаж ажиллалаа.

Ес. АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР:

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архив:

Тайлант онд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн хувийн хэрэг эх нотлох баримтыг хууль журмын дагуу хүлээн авч архивт байршуулан ажиллалаа.

- Шинээр нээсэн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн 342, газар өмчлөх эрхийн 63 хувийн хэрэг нийт 405 хувийн хэрэг архивт хүлээн авч бүртгэл хөтлөн байршууллаа. 4594 хувийн хэргийн эх нотлох баримтыг бүртгэгч нараас хүлээн авч хувийн хэрэг тус бүрт хийсэн.

2024 оны 11 сарын 20 байдлаар тус архивт Газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 5865 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн бүртгэлийн 5126 хувийн хэрэг, хадгалагдаж байна.

Одоогийн байдлаар тус архивт байнга хадгалах бүртгэлийн дэвтэр 301 х/н, түр хадгадагдах 142 дэвтэр хадгалагдаж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архив:

➤ Хуулийн этгээдийн архивт 2024 оны 11 сарын 20-ны өдрийн байдлаар шинээр бүртгэл үүссэн 566 хуулийн этгээдийн хувийн хэргийг хүлээн авч бүртгэн архивт байршуулсан. Үүнд: ХХК-58, Нөхөрлөл-2, Хоршоо-492, ТБАГ-2, ТББ-14 шинээр бүртгэгдсэн байна. Татан буугдсан 3 хуулийн этгээийн хувийн хэргийг ялгаж, шилжин явсан 1 хуулийн этгээдийн хувийн хэргийг шилжүүлсэн. Бүртгэгчээс 356 эх нотлох баримтыг хүлээн авч хувийн хэрэгт байршууллаа. Тус архивт татан буугдсан хуулийн этгээдийн хувийн хэрэг 158 хадгаламжийн нэгж, Тамга тэмдэг хураасан тухай баримт 18 хадгаламжийн нэгж, шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй 39 аж ахуй нэгжийн хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна. Архивт нийт 2025 хувийн хэрэг хадгалагдаж байна.

Д/Д	ХУВИЙН ХЭРГИЙН ИНДЕКС	АЖ АХУЙН НЭГЖИЙН ХЭЛБЭР	ТОО
1	510	Хувьцаат компани	2
2	511	Хязгаарлагдмал хувьцаат компани	903
3	512	Төрийн өмчит хувьцаат компани	1
4	513	Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	1
5	514	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар	13
6	515	Банк бус санхүүгийн байгууллага	1
7	520	Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	73
8	521	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл	25
9	525	Боловсрол соёлын байгууллага	1
10	530	Хоршоо	603
11	531	Хадгаламж зээлийн хоршоо	12
12	569	Төрийн байгууллага албан газар	97
13	568	Улсын төсөвт үйлдвэрийн газар	31
14	570	Улсын төсөвт үйлдвэрийн газар	68
15	571	Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага	113
16	572	Гишүүдэд үйлчилдэг төрийн бус байгууллага	37
17	573	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	1
18	574	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	13
19	578	Холбоо	21
20	580	Шашны байгууллага	3
21	581	Сан	5
22	509	Хэвлэл мэдээлэл ХХК	1

Иргэний улсын бүртгэлийн архив:

➤ Тус архивт 11 сарын 20-ны өдрийн байдлаар 3467 ширхэг ИУБ маягт хүлээн авч цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан сан тус бүрт байршууллаа. Үүнд: ИУБ-11 маягт 743, Иуб-12маягт 10, Иуб-13 маягт 31, Иуб-14 маягт 27, Иуб-

15 маягт 145, Иуб-16 маягт 23, Иуб-18 маягт 730, Иуб-31 маягт 2252 ширхэгийг тус тус хүлээн авсан.

➤ 2024 онд шилжин явсан 43 иргэний хувийн хэргийг архивын сангаас татан авч харъяа газарт нь хүргүүлсэн.

➤ Шилжин ирсэн 12 иргэний хувийн хэргийг хууль журмын дагуу хүлээн авч бүртгэл хөтлөн цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан архивт байрлуулсан.

➤ 2023 онд иргэний улсын бүртгэл хийхэд бүрдүүлсэн анхан шатны баримт болон бүртгэлийн дэвтэр 120 хадгаламжийн нэгжийг хүлээн авч бүртгэн ИГБББ-ийн санд байршуулав.

“ ИГБББ сан”д нийт 1608 хадгаламжийн нэгж ,

“ Хувийн хэргийн нэгдсэн сан”д 65665 иргэний хувийн хэрэг,

“ Нас баралтын сан”д 12534 иргэний хувийн хэрэг,

Мөн үндсэн мэдээллийн санд бүртгэлгүй 1648 иргэний маягт, мэдээллийн санд тодорхойгүй төлөвтэй 3283 иргэний маягт, регистрийн дугаар хүчингүй төлөвтэй 792 иргэний маягт нийт иргэний баримтын архивт 83522 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна.

Мөн 120 иргэний хүсэлтээр архивын баримтнаас төрөлт, гэрлэлт, нас баралтын лавлагаа шүүсэн.

Бусад ажлууд:

➤ УБЕГ-ын УБТАрхиваас ирсэн чиглэлийн дагуу 2024 онд устгах бичгийн түүвэр жагсаалт үйлдэн байгууллагын БНШК-ын хурлаар оруулан хэлэлцүүлж саналыг хугацаанд нь хүргүүлсэн. Архивын баримтын тоо бүртгэлийг хөтлөж байнга, түр хадгалах хадгаламжийн нэгжийн жагсаалт, ХХНЖ зэргийг гарган БНШК-ын хурлаар батлуулав.

➤ 2023 онд устгахаар ялгасан баримтуудыг УБЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу устгаж акт үйлдэн тайланг УБТАрхивт хүргүүлсэн. 2023 оны архивын хадгалалт хамгаалалтын нэгдсэн тоо мэдээ, иргэний бүртгэлийн архивт хадгалагдаж байгаа хувийн хэрэг хадгаламжийн нэгжийн тоог нэгтгэн гаргаж УБНА-т хугацаанд нь хүргүүлсэн.

Иргэн, Эд хөрөнгө, Хуулийн этгээдийн архивын санд хөтлөгдөх чийг дулаан хэмжигч, орсон гарсан, цэвэрлэгээ үйлчилгээнд тогтмол хяналт тавьж бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Арав. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

➤ Тайлангийн хугацаанд урьдчилан сэргийлэх шалгалтыг тогтмол хийж, ХША1 маягтыг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн. Мөн төлөвлөгөөт шалгалтыг 6 удаа, төлөвлөгөөт бус шалгалтыг 2 удаа, өргөдөл санал, гомдлын мөрөөр 26 удаагийн шалгалтыг хийсэн.

➤ Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйл ажиллагаанд болон иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл, сонгогч шилжилтийн бүртгэлд шалгалт хийсэн.

➤ Төлөвлөгөөт бус шалгалтын хүрээнд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санг цэгцлэх ажлын хүрээнд иргэний улсын бүртгэлийн төрсний болон нас барсны бүртгэлд давхар бүртгэгдсэн бүртгэлүүдийг шалгаж, зөрчлийг арилгуулж шийдвэрлэсэн. Мөн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн Г дугаарт давхар бүртгэсэн бүртгэлүүдийг шалгасан.

➤ Тайлангийн хугацаанд иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 2746 бүртгэлд хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн 695 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажиллалаа.

- Иргэний улсын бүртгэлийн 2408 бүртгэлд шалгалт хийж, 438 зөрчлийг шийдвэрлэсэн. Үүнд: Нэг хаятай, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, төрсөн он, сар, өдөр ижил боловч хоёр өөр регистрийн дугаараар төрсний бүртгэлд давхар бүртгэсэн 70 бүртгэл, нас барсны бүртгэлд давхар бүртгэсэн 392 бүртгэлийг тус тус нягтлан шалгаж, 232 бүртгэлийг хүчингүй болгосон. Мөн иргэний шилжилт хөдөлгөөний 497, сонгогч шилжилтийн 1346 бүртгэлийг нэгбүрчлэн шалгаж, холбогдох маягт, лавлагаанд шалгасан тухай тэмдэглэл хийж, гарын үсэг зурж баталгаажуулсан. Иргэний улсын бүртгэлийн бусад 103 бүртгэлд шалгалт хийж, зөрчлийг арилгуулсан..
- Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангийн төрсний бүртгэлд давхар бүртгэгсэн 10 бүртгэлийг шалгаж , бүртгэлийг хүчингүй болгож шийдвэрлэсэн. Мөн нас барсны бүртгэлд давхар бүртгэсэн 14 бүртгэлийг шалгаж 7 бүртгэлийг хүчингүй болгох дүгнэлт гаргасан. /2024.10/30/
- Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 280 бүртгэлд хяналт тавьж, шалгалтын явцад илэрсэн 243 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажиллалаа.
- Эрхийн улсын бүртгэлийн Г дугаарт бүртгэгдсэн газар эзэмших, ашиглах эрх нь дундын мэдээллийн сангаар дамжуулан давхар бүртгэгдэж Э, А дугаар авсан газар эзэмших эрхийн бүртгэлийг шалгаж, 204 Г дугаар бүхий газар эзэмших эрхийн улсын бүртгэлийг хаах шийдвэр гаргаж хэрэгжилтийг хангуулсан. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн бусад 76 бүртгэлийг шалгаж, 39 зөрчлийг шалгалтын явцад арилгуулсан.
- Хуулийн этгээдийн бүртгэлийн 58 бүртгэлд урьдчилан сэргийлэх хяналт тавьж, 14 бүртгэлийн зөрчлийг арилгуулж ажилласан.
- Иргэдээс ирүүлсэн 26 өргөдөл, материалыг хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэсэн.
- Хяналтын улсын байцаагчийн 41 дүгнэлт үйлдсэн бөгөөд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 13, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 22, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 6 дүгнэлт гаргасан болно.
- Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 5 хоног тутамд хүргүүлэн хянуулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн **130** хүн, **3** хуулийн этгээдэд нийт **4.190. 000** төгрөгийн торгох шийтгэл ногдуулсан.
- Хяналт шалгалтын ажлын статистик тоон мэдээг батлагдсан хүснэгтийн дагуу тухайн сарын 25-ны өдрөөр тасалбар болгон гаргаж, Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

Арван нэг. САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

11.1. Төсвийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл:

- 2024 онд **95.0** сая төгрөг улсын төсөвт төвлөрүүлэх бөгөөд 10 сарын 31-ны өдрийн байдлаар бүртгэлийн үйлчилгээний орлого **103.7** сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөний биелэлт **109%** -тай байна.

Хоёр. Төсөв, санхүү

2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар 1,478,245,500.00 төгрөгийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт авч, 1,284,317,712.92 төгрөгийг зориулалтын дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулж ажилласан.

Төсвийн гүйцэтгэл, зарцуулалт /2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар/

Үзүүлэлт	Батлагдсон төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,065,019,000.00	938,840,827.00	126,178,173.00
Үндсэн цалин	579,772,000.00	522,556,866.00	57,215,134.00
Нэмэгдэл	368,167,000.00	340,136,992.00	28,030,008.00
Унаа хоолны хөнгөлөлт	104,060,000.00	73,973,169.00	30,086,831.00
Урамшуулал	13,020,000.00	2,173,800.00	10,846,200.00
Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгал	132,714,700.00	113,209,327.00	19,505,373.00
Нийгмийн даатгалын шимтгэл	95,155,800.00	78,008,299.00	17,147,501.00
Тэтгэмжийн даатгал	9,389,500.00	9,357,737.00	31,763.00
ҮОМШ-ний даатгал	4,694,900.00	4,678,869.00	16,031.00
Ажилгүйдлийн даатгал	4,695,200.00	4,232,884.00	462,316.00
Эрүүл мэндийн даатгал	18,779,300.00	16,931,538.00	1,847,762.00
Байр ашиглалттай хол тогтмол зардал	65,000,000.00	45,724,669.92	19,275,330.08
Гэрэл, цахилгаан	12,100,000.00	5,458,919.09	6,641,080.91
Түлш, халаалт	46,400,000.00	34,731,470.83	11,668,529.17
Цэвэр, бохир ус	6,500,000.00	5,534,280.00	965,720.00
Хангамж, бараа материалын зардал	11,943,000.00	10,110,650.00	1,832,350.00
Бичиг хэрэг	6,760,000.00	5,797,500.00	962,500.00
Тээвэр, шатахуун	1,050,000.00	55,600.00	994,400.00
Шуудан, холбоо, интернэт	1,728,000.00	1,798,750.00	-70,750.00
Хог хаягдал зайлуулах, хортон	245,000.00	200,000.00	45,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх,	2,160,000.00	2,258,800.00	-98,800.00
Эд хогшил, урсгал засварын зардал	6,120,000.00	5,515,000.00	605,000.00
Багаж, техник, хэрэгсэл	2,160,000.00	2,085,000.00	75,000.00
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	640,000.00	170,000.00	470,000.00
Урсгал засвар	3,320,000.00	3,260,000.00	60,000.00
Томилолт, зочны зардал	165,000.00	0	165,000.00
Дотоод албан томилолт	165,000.00	0	165,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	1,191,300.00	805,672.00	385,628.00
Бусад нийтлэг АҮТХураамж	1,100,000.00	778,000.00	322,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	91,300.00	27,672.00	63,628.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	0	0	0.00
Бараа үйлчилгээний бусад зарда	4,780,000.00	440,000.00	4,340,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага х	4,780,000.00	440,000.00	4,340,000.00
Холбооны суваг ашигласны хөлс	3,850,000.00	1,815,000.00	2,035,000.00
Бусад нийтлэг АҮТХураамж	3,850,000.00	1,815,000.00	2,035,000.00
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	187,462,500.00	168,662,239.00	18,800,261.00
Хөдөө орон нутагт тогтвор суур	186,802,500.00	168,122,239.00	18,680,261.00
Нэг удаагийн тэтгэмж, шаг урам	660,000.00	540,000.00	120,000.00

Гурав. Өглөг, авлагын талаар:

- Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтын хувьд баталсан төсвийн хуваарийн дагуу явж байгаа боловч зарим зардлуудад хувиарласан төсөв хүрэлцэхгүй байсан учир тооцоо, судалгаа гаргаж УБЕГ-н Санхүү төлөвлөлтийн газарт сар бүр хүргүүлэн

төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан зарим зардлуудыг өөр эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэх ажлуудыг хийсэн.

2024.11.15-ны өдрийн байдлаар өглөг болон авлага үүсээгүй байна.

Дөрөв. Нэмэлт санхүүжилтын талаар:

➤ 2024 оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар нэмэлт санхүүжилт ЗДТГазраас 26,744,000.00 төгрөгийн санхүүжилт авч 2024 оны 5-р сараас эхлэн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний нийт 33 албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл сар бүр 10 хувь олгосон.

Мөн УБЕГазраас УИХ-ын сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 89,799,600.00 төгрөг, Орон нутгийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 80,407,900.00 төгрөг нийт нэмэлт санхүүжилт 196,951,500.00 төгрөгийн санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулан ажиллалаа.

Тав. Аудит, хяналт шалгалтын байгууллагаас хийсэн шалгалтаар зөрчил дутагдалгүй ажилласан байдал, НББОУС, холбогдох хууль тогтоомж, заавар, журам мөрдөж ажилласан байдал:

➤ Аймгийн Төрийн аудитын газраас 2024.02.21-ны өдрийн №38 тоотой 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангаар “ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ” өгсөн бөгөөд ямар нэгэн зөвлөмж, акт, албан шаардлага өгөөгүй болно.

Мөн Төрийн аудитын газраас 2024 оны УИХ болон АНСДИТХ-ын сонгуулийн санхүүжилт болон гүйцэтгэлд хийсэн аудитаар зөрчилгүй ажилласан.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2024 оны 08 сарын 27-нд Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2023 оны биелэлтийг 96%-тай дүгнэж, Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний сунгалтыг хийсэн.

Зургаа. Тайлан мэдээ

➤ 2024 оны 11-р сарын байдлаар тус хэлтэс сар, улирал, өдөр тутам гаргах тайлан, мэдээг хугацаанд нь гаргаж харъяалагдах байгууллагад хүргүүлж ажилласан.

Үүнд:

1. Тус хэлтсийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сарын бүрийн 2-ны өдрийн дотор Төрийн сангийн хэлтсээр баталгаажуулан УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.
2. Үнэт цаасны тайлан мэдээг сар бүрийн 5-ны өдрийн дотор УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч Ц.Ганчимэгт ts.ganchimeg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлсэн.
3. 2023 оны жилийн эцэс, 2024 оны 1,2,3-р улирлын санхүүгийн тайланг дараа сарын 15-ны өдрийн дотор УБЕГазрын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч А.Наранцэцэгт a.narantsetseg@burtgel.gov.mn цахим шуудангаар хүргүүлж, сангийн яамны Э тайланд шивж нэгтгүүлэн ажилласан.
4. Тус хэлтсийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны дотор бэлтгэн гаргаж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлсэн.
5. 2023 оны 4-р улирал, 2024 оны 1,2,3-р улирлын ХХОАТ-н тайланг гарган дараа сарын 15-ны өдрийн дотор Аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн.

Долоо. Төсвийн ил тод нээлттэй байх зарчим, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр хийсэн ажил

➤ Байгууллагын үйл ажиллагаа болон төсөв, санхүүгийн гүйцэтгэлийг хэлтсийн байрны мэдээллийн самбарт тухай бүр байршуулсан.

- 2024.10.31-ны өдрийн байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу <https://info.shilendans.gov.mn/> цахим хуудсанд 139 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хоцорсон, огт оруулаагүй мэдээлэл байхгүй бөгөөд 2023 оны 4-р улирал, 2024 оны 1,2,3-р улирлын мэдээллийг хугацаанд нь илгээсэн.

Найм. Үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хөрөнгө оруулалт.

- 2024 оны эхэнд барилга, авто машин, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, програм хангамж гэсэн 5-н бүлгийн 852,745,081.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2024.11.15-ны байдлаар 812,005,861.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.

ТӨБЗГазрын 2024.06.13-ны өдрийн 324 дүгээр тогтоолоор 45,516,800.00 төгрөгийн тоног төхөөрөмж, 70,000.00 төгрөгийн тавилга эд хогшил нийт 45,586,800.00 төгрөгийн үндсэн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгийн зөвлөлийг хуралдуулж 2024.06.24-ны өдрийн №01 дүгээр хурлын тэмдэглэл, дүгнэлтээр үндсэн хөрөнгийг устгах ажлыг зохион байгуулж, хууль журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгасан.

ТӨБЗГазрын 2024.06.17-ны өдрийн А-1/1108 тоот албан бичгээр УБЕГазраас балансаас балансад шилжүүлэн бүртгэх үндсэн хөрөнгийн жагсаалтын дагуу 3,660,580.00 төгрөгийн 1 ширхэг зөөврийн компьютерийг тоног төхөөрөмжийн дансанд орлогот бүртгэсэн.

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024.11.13-ны өдрийн хурлын тэмдэглэл, дүгнэлтийг үндэслэн УБЕГазрын санхүү аж ахуйн хэлтэст 2024.11.15-ны өдрийн 15/432 тоот албан бичгээр 8,500,000.00 төгрөгийн үнэ бүхий авто тээврийн хэрэгслийн дансанд бүртгэлтэй Тоёота Ланд-80 авто машины актлах саналыг хүргүүлсэн.

Тус хэлтэс нь орон сууцны 3 өрөө байртай ба одоогоор ямар нэг үйл ажиллагаа явагддаггүй байна.

Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.

Мөн хэлтсийн даргын 2024 оны А/09 дугаар тушаалаар 2024 оны эхний хагас жилийн хөрөнгийн тооллого явуулсан.

Ес. Бараа материалын бүртгэл хөтлөлт, тайлагнасан байдал

- Улсын бүртгэгч нарын үнэт цаасны тайланг авч нэгдсэн тайланг гаргаж ажилладаг ба Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдүүлэн хяналтын улсын байцаагчаар хүчингүй болгуулан ажиллаж байна.

- Аж ахуйн материал, бичиг хэрэг, бэлэн бүтээгдэхүүн, бусад бараа материалын тайланг сар бүр няраваар гаргуулан хяналт тавьж ажиллалаа.